



2024 оны үйл ажиллагааны тайлан



ЭРХЭМ ЗОРИЛГО

БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ НЬ ЗОЧДОО ДЭЭДЭЛСЭН, ЗОЧИН БҮРТЭЭ ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ ҮЙЛЧИЛДЭГ БАЙГУУЛЛАГА.

АЛСЫН ХАРАА


“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ НЬ ЗОЧЛОХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРТ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ БАРИМТЛАН, ГАДААД ДОТООДЫН БАЙГУУЛЛАГУУДАЙ НЯГТ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ЧАДВАРЛАГ МЭРГЭЖЛИЙН БАГ ХАМТ ОЛНЫГ БҮРДҮҮЛЭН ОРЧИН ҮЕИЙН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИУДЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЭН ОЛОН УЛСЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ БОЛОН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИД НИЙЦСЭН “БАЯНГОЛ БРЭНД”-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ БУЙ БОЛГОНО.

ЗОРИЛТ

ЗОЧИД ГИЙЧДИЙН АЯ ТУХТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ.

ТУРШЛАГАТАЙ МЭРГЭШСЭН АЖИЛЧДЫГ БЭЛДЭХ.

БУУДЛЫН ОР АШИГЛАЛТЫГ БУУРУУЛАХГҮЙГЭЭР, БОРЛУУЛАЛТЫН НИЙТ ОРЛОГЫГ ӨМНӨХ ЖИЛЭЭСЭЭ ТОГТМОЛ ӨСГӨХ.



Регистрийн
дугаар

2026899



Компанийн
хаяг

Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө



1964 онд
байгуулагдсан



Хувьцаа
эзэмшигчдийн
тоо

1058 хувьцаа
эзэмшигчидтэй



1991 онд хувьцаат компани
болж хувийн хэвшлийн
аж ахуйн нэгж болон
өөрчлөгдсөн



2024 онд ISO9001:2015
Стандартыг дахин
баталгаажуулсан



Үйл
ажиллагааны
чиглэл

Зочид Буудал
Зоогийн газар



350 орчим зочин
хүлээн авах, 6 ангилалын
204 өрөө



2003 онд 4 одны
зэрэглэл авсан
Үндэсний 100% хөрөнгө
оруулалттай зочид
буудал



300-400 зочин зэрэг хүлээн авах
“Баянгол ресторан”.
Үндэсний хоолоор үйлчлэх
“Монголын нэг өдөр ресторан”.
Дээд зэрэглэлийн виноны
“Wine House” Ресторан.



Зочны угаалга, өрөөний үйлчилгээ,
үсчин гоо сайхан, саун, фитнес
интернэт зэрэг 20 гаруй төрлийн
дагалдах үйлчилгээг зочдод үзүүлж
байна.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл




➤ Тус компани нь 2024 онд түүхт 60 жилийн ойгоо угтан зочноо дээдэлсэн зочин бүрт чин сэтгэлээсээ үйлчилдэг байгууллага болохын хувьд зочны ая тух, тавлаг байдлыг дээшлүүлж хөрөнгө оруулалт чанарын жил болгох зорилт тавьж ажилласан.

Үүнд:

- ✓ Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартаа дахин баталгаажуулж түүнд шаардлагатай заавар, журам стандартыг сайжруулах
- ✓ Борлуулалтын орлогыг нэмэгдүүлж бүтээгдэхүүн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх
- ✓ Зорилтот зах зээлдээ идэвхжүүлэлт хийж, үйлчилгээний хүрээг тэлэх
- ✓ Эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын аюулгүйн зөрчил, доголдолгүй ажиллах
- ✓ Зочны сэтгэл ханамжийг нэмэгдүүлж харилцагчийн хүрээг өргөтгөх
- ✓ Туршлагатай мэргэшсэн ажилчид бэлтгэх, тэднийг сургах
- ✓ Хөрөнгө оруулалтын зорилтын хүрээнд үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулж, зочны өрөөнүүдийн тавилга тоноглолыг шинэчлэн, барилгын дотоод орчны засвар үйлчилгээг сайжруулж, зочны аюулгүй байдал тав тухыг сайжруулж галын дохиолол, камерын систем сайжруулах зэрэг ажлыг үе шаттай гүйцэтгэж ирсэн.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

- ✓ Тайлант онд нийт орлого өмнөх оноос 20%-иар өссөн. Зочид буудлын орлого 2023 онтой харьцуулахад 26 хувь өссөн, хоол үйлдвэрлэлийн орлого 10 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Эздийн өмч нь орлогын өсөлтийг дагаж 9.74% өссөн үзүүлэлттэй байна.




Орлогын задаргаа

/2023-2024 он/

Орлогын төрөл	2023 он		2024 он		Өсөлт /бууралт/	
	Дүн /сая.төгрөг/	Эзлэх хувь	Дүн /сая.төгрөг/	Эзлэх хувь	Дүн /сая.төгрөг/	Хувиар
Буудал	4,370,141.26	47.80%	5,523,900.34	50.19%	1,153,759.09	26%
Ресторан	4,081,690.77	44.60%	4,487,878.25	40.78%	406,187.49	10%
Хүүний орлого	204,156.49	2.20%	348,048.51	3.16%	143,892.02	70%
Түрээсийн орлого	235,918.33	2.60%	273,087.91	2.48%	37,169.59	16%
Ногдол ашгийн орлого			13,578.70	0.12%	13,578.70	
Бусад орлого	252,853.23	2.70%	359,702.10	3.27%	106,848.87	42%
НИЙТ	9,144,760.07	100%	11,006,195.82	100%	1,861,435.75	20%

НИЙТ ОРЛОГО /2024 ОН/



- Буудал
- Ресторан
- Хүүний орлого
- Түрээсийн орлого
- Ногдол ашгийн орлого
- Бусад орлого

БУУДЛЫН БОРЛУУЛАЛТЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТ /2020-2024/

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Нийт ашиглах боломжтой өрөө	76,260	76,260	74,095	74,095	74,460
Борлуулсан өрөөний тоо	2,027	8,304	13,371	18,232	21,600
Өрөө ашиглалтын хувь	3%	11%	18%	25%	29%



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

1. Бие даах чадварын коэффициент: Бие даах чадварын коэффициент нь нийт хөрөнгөнд эзэмшигчдийн хөрөнгийн эзлэх хувийн жинг харуулдаг. Энэ хувийн жин хэдий чинээ өндөр байна тэр хэмжээгээр өр төлбөр бага гадны санхүүгийн эх үүсвэрээс хараат бус байгааг харуулдаг. Манай байгууллагын хувьд 95% байгаа нь сайн үзүүлэлт юм.

2. Дансны авлагын эргэц: Тайлант онд авлага нь хэдэн удаа эргэж мөнгө болсныг харуулдаг үзүүлэлт юм. 2024 онд 38.2 болсон байна.

3. Бараа материалын эргэц: Барааг хэр хурдан борлуулж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Манай байгууллагын хувьд дундаж бараа материал 2023 онд 3.8 удаа эргэж байсан бол 2024 онд 3.5 болж өмнөх оны мөн үеэс 8% буурсан байна.

4. Хөдөлмөрийн бүтээмж /төг/: Байгууллагын ажилтан тус бүрд ногдох хөдөлмөрийн бүтээмжийг илэрхийлнэ. 2023 онд хөдөлмөрийн бүтээмж нэг ажилтанд 59,633 төг ногдож байсан бол 2024 онд 69,531 төг болж 17% иар нэмэгдсэн нь байгууллага өөрийн нөөц боломжоо бүрэн дайчилсан ажиллаж борлуулалтын орлогоо нэмэгдүүлсний үр дүн юм.


5. Орлогын нэг төгрөгт ногдох ашиг: Борлуулалтын 1 төгрөг тутамд хэдэн мөнгөний ашиг олж байгааг харуулна. 2023 оны борлуулалтын орлогын 1 төгрөгөөс 53 мөнгөний ашиг олж байсан бол 2024 онд 60 мөнгө болж өмнөх оноос 7 мөнгө буюу 9% өссөн байна.

6. Цэвэр эргэлтийн хөрөнгө: Энэхүү үзүүлэлт нь хэдий чинээ өндөр байна тэр хэмжээгээр гаднын эх үүсвэрээс хараат бус байна. 2023 онд өмнөх оноос 11%-р өссөн байна.

7. Эргэлтийн харьцаа: Эргэлтийн харьцаа нь өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөөрөө 2 дахин болон түүнээс дээш барагдуулах чадвартай бол зохистой гэж үздэг. Манай байгууллагын хувьд 13.8 байгаа нь маш сайн үзүүлэлт юм.

Д/д	Үзүүлэлт	2022Q4	2023Q4	2024Q4
1	Бие даах чадварын коэффициент	0.96	0.95	0.95
2	Дансны авлагын эргэц	24.0	54.9	38.2
3	Бараа материалын эргэц	3.0	3.8	3.5
4	Хөдөлмөрийн бүтээмж /төг/	41,714.6	59,633.6	69,530.3
5	Орлогын нэг төгрөгт ногдох ашиг /мөн/	0.45	0.53	0.6
6	Цэвэр эргэлтийн хөрөнгө /тэр.төг/	19.1	22.0	24.5
7	Эргэлтийн харьцаа	16.3	12.0	13.8

БОРЛУУЛАЛТАА НЭМЭГДҮҮЛЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭГЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД /2024 ОН/





- ✓ Золголтын арга хэмжээ
- ✓ Зочид Буудлын өрсөлдөгчийн судалгаа
- ✓ Буудлын гэрээ шинэчлэх
- ✓ Олон улсын ONLINE захиалгын урамшуулал
- ✓ Quiz night /Main, Rookie/
- ✓ Дотоодын зочдодоо зориулсан БУУДЛЫН ӨРӨӨНИЙ урамшуулал
- ✓ Монгол хоолны LUNCH SET
- ✓ Хонины шарсан гуя
- ✓ Valentine's day /Special offer/
- ✓ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн багц
- ✓ Wine House Restaurant-нд 8 төрлийн SET
- ✓ Жуулчны цэс / цагаан хоол, монгол хоол/
- ✓ Storepay үйлчилгээ /Hotel, Restaurant, Fitness/
- ✓ Төгсөлтийн баярын хүлээн авалтын тусгай цэс
- ✓ Хуримын чимэглэлийн шинэчлэл
- ✓ Төрсөн өдрийн урамшууллын багц
- ✓ “Wedding Expo Mongolia-2024”-д оролцов
- ✓ Сонголтот хүлээн авалтын цэс
- ✓ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн BRUNCH BUFFET
- ✓ Bayangol TERRACE /Багтаамжийг нэмсэн, TV, Speaker, Draft Beer, Cocktail/
- ✓ Naadam FIESTA 2024
- ✓ EURO 2024 хөлбөмбөг, Paris 2024 олимпыг тус тус TERRACE дээр үзүүлэв
- ✓ Наадмын дугуй хуушуур

2024 оны борлуулалт, маркетингийн үйл ажиллагааны зорилтын хүрээнд

- ✓ Улаанбаатар хотын өрсөлдөгч зочид буудлуудын үндсэн үнийн судалгааг хийж зочид буудлын суурь үнийг 15% -р нэмсэн.
- ✓ Хоол ундааны үйлчилгээний үнийг үйлчилгээний хөлс болон бараа материалын өсөлттэй холбогдуулан зохистой түвшинд байлгах
- ✓ Буудлын онлайн борлуулалтыг идэвхжүүлэх үүнд :
- ✓ Booking.com – г идэвхжүүлэн гишүүнчлэлийн эрхийг нэмэгдүүлэн захиалгын тоо нэмэх
- ✓ Agoda .com . Expedia.com . Trip.com онлайн сувгуудтай шинээр холбож захиалгын хувийг өсгөх
- ✓ Олон улсын сүлжээ болон үндэсний зочид буудлуудад харьцуулалтын судалгааг хийсний үндсэн дээр Бүх үйлчилгээний үнэнд үйлчилгээний хөлс / Service charge/ оруулах талаар судалгаа хийх
- ✓ Ажиллах хүчны хувьд албаны ажилчдыг шинэ залуу мэргэжлийн ажилчдаар 80 % шинэчилэх
- ✓ Зар сурталчилгааны салбар дээр үнийн судалгаа хийж , үнийг шинэчлэн нэмсэн.
- ✓ Шинэчилсэн үнээр гэрээт байгууллагуудтай гэрээнүүдийг шинэчлэн байгуулж эхэлсэн.
- ✓ Зочин тосох, үдэх үйлчилгээн дээр нэмэлтээр ВИП такситай гэрээ байгуулж ажиллаж эхэлсэн.
- ✓ Захиалгын системийг шинэчлэхээр бэлтгэлээ бүрэн хангасан.
- ✓ Зочны өрөөний мэдээллийн хавтасны мэдээллийг иж бүрэн шинэчилсэн.
- ✓ Өрөө үйлчилгээ , ТВ суваг , Мэдээллийн хавтасны мэдээллүүдийг бүрэн QR болгосон.
- ✓ Зочны өрөөнүүдийн зураг авалт хийж мэдээллийн сувгуудын зурган мэдээллийг бүрэн шинэчилсэн.
- ✓ Монголын нэг өдөр, Wine house ресторануудын борлуулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг сайжруулах чиглэлээр тус бүрд нь төсөл бичсэн

2024 оны хөрөнгө оруулалт, их засварын ажил

Тус компани нь 2024 оны зорилтын хүрээнд хөрөнгө оруулалтын жил болгон зарласантай холбоотойгоор үйлчилгээний хэсэг нэгжүүд, үйлдвэрлэлийн цехүүд, барилгын засвар үйлчилгээнд гол хөрөнгө оруулалт хийсэн жил байлаа. Буудлын өрөөнүүдийн тохжилтод 1,285,152,469 төгрөг, Тоног төхөөрөмж, машин, бараа материалд 425,443,304 төгрөг, Барилгын их засвар, галын дохиолын иж бүрэн систем шинэчлэл болон дотоод хяналтын камерын иж бүрэн системд 100,000,000 төгрөг, гадна тохжилтод 274,930,000 төгрөг тус тус зарцуулсан. Ажилчдын ажлын болон хооллох орчныг сайжруулан хоолны танхим, хувцас солих өрөө зэргийг шинэчлэн засварлаж тохилог орчинг бүрдүүлсэн.



2024 оны хөрөнгө оруулалт, их засварын ажил

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ИХ ЗАСВАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Д/д	Хийгдсэн ажлын нэр	Дүн /төгрөг/
1. Буудлын өрөөнүүдийн тохжилт		
1	Буудлын нийт 21ш өрөөний иж бүрэн дотоод засал /7люкс, 14 стандарт/	909,071,634
2	Буудлын 2 давхрын коридорын иж бүрэн засал	
3	21 өрөөний тавилга,эд хогшил	376,080,835
	Нийт	1,285,152,469
2. Тоног төхөөрөмж, машин, бараа материал		
4	Галын дохиоллын иж бүрэн систем шинэчлэл	100,000,000
5	Дотоод хяналтын камерын иж бүрэн систем	
6	Газын байгууламж, тоног төхөөрөмжийн иж бүрэн шинэчлэл	39,581,954
7	Автомашин, хөгжмийн тоног төхөөрөмж, гал тогооны тоног төхөөрөмж, буудлын цагаан хэрэглэл, нэг удаа	285,861,350
	Нийт	425,443,304
3. Барилгын их засвар, гадна тохжилт		
10	Гадна хашаа, ногоон байгууламж сайжруулах ажил	25,000,000
11	А, Б буудлын барилгын гадна фасад будсан	183,000,000
12	Баянгол рестораны дээвэр будсан	
13	Бохирын 26м шугам шинэчлэн 2ш худаг, 2ш кольцо шинээр хийсэн	14,500,000
14	Ажилчдын хоолны газар, усанд орох , хувцас солих өрөөний засварыг хийсэн	24,000,000
15	Баянгол рестораны коридорыг засварласан	
16	ВН, Угаалгын цех агааржуулалтын хоолойг шинэчлэсэн ба БГ рестораны цагаан савны агааржуулалтын системийн засвар үйлчилгээг хийж сэнсийг шинээр сольсон	28,430,000
	Нийт	274,930,000
	<u>НИЙТ ДҮН</u>	<u>1,985,525,773</u>

Хүний нөөц бүрдүүлэлт, бодлогын хүрээнд

- ✓ Хүний нөөцийн бүрдүүлэлт нь шаардлагатай тоо, чанарыг хангах чадварлаг ажил горилогчдыг бүрдүүлэх, ингэснээр байгууллагын хувьд тухайн ажлын байранд хамгийн сайн тохирох хүмүүсийг шилж сонгон шалгаруулах, сургах, тогтвор суурьшилтай ажиллуулахад гол анхаарлаа тавьж мэргэжлийн сургуулиудтай хамтран ажиллаж байна.
- ✓ 2024 оны байдлаар манай компани 100 гаруй ажиллагсадтай ажиллаж, үүнээс 54 хувь нь эмэгтэй, 46 хувь нь эрэгтэй ажилтнууд байна. Ажиллах хүч хомсдолтой өнөө үед ажилтнаа дасан зохицуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК СУРГАЛТ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД

- “Баянгол зочид буудал” ХК нь сургалт зохион байгуулахдаа зөвхөн хийсэн гэдэг нэр зүүх биш үр дүн гаргахад илүү чиглэдэг. Хүн бол аливаа байгууллагын хамгийн үнэ цэнтэй баялаг бөгөөд энэ баялгийн чанар тасралтгүй өсөж, сайжирч байх ёстой бөгөөд сургалт нь чухамдаа байгууллагын ажилтнуудад цэцэглэн хөгжих боломжийг олгодог. Тиймээс сургалтад зарцуулсан хүчин чармайлт, зардал, цаг хугацаагаа хамгийн сайн үр дүнд хүргэхэд анхаарч ажилладаг.
- Сургагч багшийн мэргэжлийн ур чадварыг харж сонгон, ажилчдаа 100 хувь хамруулахыг эрмэлздэг.
- Сургалт гэхээр уламжлалт лекц биш трэйнинг хэлбэрийн сургалтыг сонгож практик ач холбогдолтой болгодог. Мөн хамт сургалтад сууж буй бусад оролцогчидтойгоо харилцах, өөрийн туршлагаа тэдэнтэй хуваалцах нь бодит ертөнцөөс сурах боломж олддог.
- Манай байгууллагад мэргэжлийн сургалтууд давамгайлдаг бөгөөд сургагч багшийг өөрийн хамт олноосоо гаргах, бэлдэх ажлуудыг зохион байгуулж байна.
- Мэргэжлийн сургуулиудтай гэрээ байгуулан хамтарч ажиллаж байна.



Нийгмийн хариуцлагын хүрээнд




- 2024 оны 4-р сараас эхлэн Улаанбаатар хотын хүнсний хог хаягдалыг дахин боловсруулах дунд төвшний төсөлд хамрагдсан.
- Төслийн хүрээнд манай байгууллагаас 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж төслийг амжилттай хэрэгжүүлсэн.
- Ажлын үр дүнд өөрсдийн гал тогооноос гарсан хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж 60кг орчим бордоог гаргаж өөрсдийн байгууллагын хэрэгцээнд хэрэглэж, үргэлжлүүлэн ажиллаж байна.
- Зүрх мартаггүй төслийг дэмжиж хамтран ажилласан.
- Олимпийн баг тамирчдыг дэмжиж ажилладаг.



Онцлох үйл явдлууд

- 2024 онд тавьсан зорилтын хүрээнд
- Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартын баримт бичгийн үйл ажиллагаанд хяналт тавих шинэчлэл хийх стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор чанарын менежментийн тогтолцоо iso 9001:2015 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснийг баталгаажуулж Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ чиглэлээр
- Дугаар ММС/241121 тоот олон улсын чанарын гэрчилгээг эзэмших эрхийг баталгаажуулж чадлаа.
- Баянгол зочид буудал ХК-ийн түүхт 60 жилийн ой тохиосонтой холбоотойгоор тусгай төлөвлөгөөг боловсруулан батлуулж үе шаттайгаар төлөвлөгөөт ажлыг зохион байгуулж байна. Үүнд
 - Ажилчдад зориулсан 60 жилийн ойн арга хэмжээ
 - Ахмад ажилчиддаа зориулсан 60 жилийн ойн арга хэмжээ
 - 60 жилийн ойн хүрээнд спорт, урлагын арга хэмжээ
 - 60 хоногийн BRUNCH зоогийн үйлчилгээг зочдод зориулан зохион байгуулж үйлчилж байна.
 - 60 жилийн ойгоо баримтжуулж түүхэн кино, нэвртгүүлэгүүд хийж байна.

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСНИЙГ БАТАЛГААЖУУЛСАН.

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: MMC/241121

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 5

Чанарын менежментийн тогтолцоо
ISO 9001:2015
/MNS ISO 9001:2016/
олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснийг баталгаажуулав.

Хамрах хүрээ: **Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ**

Анх олгосон: 2024.12.24 Олгосон огноо: 2024.12.24
Хүчинтэй огноо: 2027.12.23

Баталгаажуулалтын байгууллагын нэр:
МОН МАЙНИНГ СЕРТИФИКЕЙШИН ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.БАЯРХУУ

Баталгаажуулалтын байгууллагын хаяг:
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Б.Доржийн гудамж, УБ Сүйт, 2 давхар, 206 тоот





CERTIFICATE

Certificate No. MMC/241121

BAYANGOL HOTEL JSC

Address: Chinggis Avenue -5, 1st khoroo, Sukhbaatar District, Ulaanbaatar-14251, Mongolia

This is to certify that
ISO 9001:2015
/MNS ISO 9001:2016/
has established and applies a Quality Management System for

Scope: **Hotel and Restaurant services**

Original Issued Date: 2024.12.24 Issued Date: 2024.12.24
Expiry Date: 2027.12.23

Certification Body:
MON MINING CERTIFICATION LLC




EXECUTIVE DIRECTOR
G.BAYARKHUU

Address of Certification Body:
#206, 2nd Floor, UB Suite, Bayanzurkh District, Ulaanbaatar-13361, Mongolia

“Баянгол зочид буудал” ХК-ийн түүхт 60 жилийн ойн арга хэмжээ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болж компанийн хөгжил, цэцэглэлтэнд гар бие оролцож байгаа ажилтнуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

Арга хэмжээг нээж Гүйцэтгэх захирал Х.Цэндбаяр баяр хүргэн үг хэлж, олон жил үр бүтээлтэй ажилласан нэр бүхий ажилтнуудад Төрийн дээд одон медаль, яамд, нийслэлийн шагналыг гардууллаа. Ойн арга хэмжээ халуун дулаан уур амьсгал, сэтгэлийн хөөр баяраа хуваалцсан сайхан дурсамжаар дүүрэн болж өндөрлөлөө.


Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:

Д.Ганчимэг – Буудлын үйлчилгээний албаны ахлах менежер, Э.Нармандах -МНӨ рестораны тогооч, Ч.Эрдэнэбилэг – тогооч, Л.Жимсээ – Нарийн боовны тогооч



БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХТ 60 ЖИЛИЙН ОЙН АХМАДУУДЫН ХҮНДЭТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

• “Баянгол зочид буудал” ХК нь түүх 60 жилийн ойгоо тохиолдуулан “Элдэв эрдэнэт” хэмээх модон могой жилийн сар шинийн босгон дээр (2025.02.19) байгууллагадаа байгуулсан гавьяатай, туулсан замтай эрхэм ахмадуудаа “Баянгол ресорт” салбар дээрээ хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Компанид 130-аад ахмад ажилтан харъяалагддаг. “Баянгол зочид буудал” ХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Цэндбаярмэндчилгээ дэвшүүлж, компанийн авч хэрэгжүүлж буй ажлуудаас танилцуулж, удахгүй болох сар шинийн баяр, гарч буй модон могой жилийн мэндийг дэвшүүлэн, эрүүл энхийг хүслээ. Мөн ахмадуудын санал сэтгэгдлийг сонсож, илэн далангүй ярилцлаа.



БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХТ 60 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН СПОРТЫН ӨДӨРЛӨГ

• Спортын тэмцээн уралдаанаар дамжуулан хамт олноороо чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэн эрүүл амьдралын хэв маягийг дэмжих гэх мэт олон давуу талтай билээ. “Баянгол зочид буудал” ХК-ын түүхт 60 жилийн ойг тохиолдуулан жилийн төлөвлөгөөнд тусгасны дагуу байгууллагын спортын өдөрлөг 2025 оны 01 сард болж өнгөрлөө. Өдөрлөгт сагсан бөмбөг, гар бөмбөг, теннис 3 төрөлт тэмцээнээр маш өрсөлдөөнтэй явагдаж, 2024 оны аваргуудаа шалгарууллаа.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Баянгол зочид буудал” ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаа баталж, уг журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

2023-2024 онд Төлөөлөн Удирдах Зөвлөл нь журмаар тогтоосон эрхийн хүрээнд доорх асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно. Үүнд:


Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах, компанийн үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах чиглэл өгөх, хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах, компанийн гүйцэтгэх удирдлагатай гэрээ хийх, дүгнэх, аудитын байгууллагыг сонгох, ногдол ашиг хуваарилах талаар шийдвэр гаргах, Төлөөлөн удирдах зөвлөл түүний хороодын ажиллах журам, компанийн засаглалын журмууд батлах зэрэг компанийн дүрмээр тогтоосон асуудлуудыг хэлэлцэж нийт 8 удаа хуралдаж 8 тогтоол 6 хурлын тэмдэглэл, 4 журам батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан болно.

ОН	НЭГЖ ХУВЬЦААНД ОЛГОСОН НОГДОЛ АШИГ /Төг/
2017	355₮
2018	355₮
2019	360₮
2020	Цар тахал /COVID-19/ улмаас компанийн үйл ажиллагаа зогсож уг онуудад ногдол ашиг хуваарилаагүй.
2021	
2022	300₮
2023	300₮

“Төлөөлөн Удирдах Зөвлөл”-ийн 2025 оны 2 дугаар сарын 18-ний өдрийн №02 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 330 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

BNG- Хувьцааны арилжаа



	2024.12.04
Нээлтийн ханш:	31,020
Хаалтийн ханш:	31,020
Авах дээд үнэ:	31,020
Зарах доод үнэ:	31,020
Арилжигдсан өдөр	34
Нийт гаргасан хувьцаа:	423,065
Арилжигдсан ширхэг:	2,312
Нэгж хувьцааны зах зээлийн дундаж үнэ:	32,907
Арилжааны дүн	77,717,280



Bayangol
HOTEL

Чингисийн өргөн чөлөө-5
Улаанбаатр 14251, Монгол Улс
Утас: +976-11-328869,
Факс: +976-11-326794
Гар Утас: 9900-8140
И-мэйл: info@bayangolhotel.mn
www.bayangolhotel.mn



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний
өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны
бүртгэлийн журмын" -ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/		2024.01.01-2024.12.31	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Баянгол зочид буудал ХК УБГД:0001657 Утас: 11-312255	РД:2026899 ҮЦКод: BNG	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Аялал жуулчлал /Зочид буудал, зоогийн газар/		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	"Фискал Аудит" ХХК		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	423,065 ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий ня-бо С.Алтантуяа Хянасан: ТУЗ-ын дарга Д.Аюуш		
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	24,035,605,180.80	26,476,825,211.80
	Эргэлтийн бус хөрөнгө	15,049,545,782.00	16,130,734,523.90
	Нийт хөрөнгө	39,085,150,962.80	42,607,559,735.70
	Өр төлбөр эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	2,008,143,319.50	1,923,952,417.30
	Эздийн өмч	37,077,007,643.20	40,683,607,318.40
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	39,085,150,962.70	42,607,559,735.70
	Орлогын тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл
Борлуулалтын орлого (цэвэр)		8,646,869,594.00	10,360,022,698.90
Борлуулалтын өртөг		(4,059,182,830.48)	(4,337,977,513.49)
Нийт ашиг (алдагдал)		4,587,686,763.52	6,022,045,185.41
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		3,184,267,489.34	4,204,975,590.17
Орлогын татварын зардал		(348,558,354.74)	(484,036,014.98)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		2,835,709,134.60	3,720,939,575.19
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Өмч	54,998,450.00	54,998,450.00
	Халаасны хувьцаа	(67,212,874.71)	(67,212,874.71)
	Нэмж төлөгдсөн капитал	102,280,625.00	102,280,625.00
	Хуримтлагдсан ашиг	36,986,941,442.91	40,593,541,118.10
	Нийт эздийн өмч	37,077,007,643.20	40,683,607,318.39

	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	<i>Үзүүлэлт</i>	<i>Эхний үлдэгдэл</i>	<i>Эцсийн үлдэгдэл</i>
		Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,525,745,913.11	3,287,236,026.20
		Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	204,156,486.39	(998,171,030.40)
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,287,217.50)	(54,126,402.00)
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,725,615,182.00	2,234,938,593.80
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,137,384,775.00	13,862,999,957.00
		Мөнгөн хөрөнгийн үнэ цэнийн бүүралт болон валютын ханшийн өөрчлөлт	1,305,595,281.70	(69,378,937.57)
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,862,999,957.00	16,028,559,613.23
1.1	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>			
	- Хавсралтаар оруулав.			
1.2	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>			
	- Хавсралтаар оруулав.			
2.	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>			
2.1	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	Бие даалтын коэффициент 95% Өр эзний өмчийн харьцаа 5% Нийт ашгийн хувь 58% Цэвэр ашгийн хувь 36%		
2.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Эргэлтийн харьцаа 13.8 Түргэн хөрвөх харьцаа 13.1 Авлагын эргэц 1.1		
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	- Инфляци болон гадаад валютын ханшийн өсөлт, нийлүүлэлтийн гинжин сүлжээний үнийн өсөлтөөс хамаарч түүхий эд материалын үнэ өссөний улмаас бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөхөд шууд нөлөөлж байна. Үүний эсрэг бид бэлтгэн нийлүүлэгчид болон үйлчлүүлэгчидтэй урт хугацааны түршид хамтран ажиллах гэрээ хийх, бараа үйлчилгээг солилцох замаар бие биенээ дэмжин ажиллаж байна.		
2.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	- Балансын гадуур ажил гүйлгээ байхгүй болно.		
2.5.	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	- Зээл аваагүй.		
3.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/.</i>			
	- Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл тайлант жилд хийгдээгүй болно.			
4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>			
	2024 оны 4 сараас ажилчдын цалинг 30%-иар нэмж, улирал бүр Ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох журмын дагуу ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэн KPI буюу урамшуулалт цалинг улирал бүр олгож байсан.			
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>			

<p>Хувьцаа эзэмшигчдийн хурал: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит ХХХ хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 15 цагт цахимаар зохион байгуулсан. Хурлын материалыг 4 дүгээр сарын 30нд СЗХ, МХБ-д хүргүүлсэн.</p> <p>ТУЗ-ийн гишүүд: 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ХЭ-ийн хурлаар ТУЗ-д сонгогдсон 9 гишүүн (хараат бус 4 гишүүн, ердийн 5 гишүүн) ажиллаж байна.</p> <p>Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ: СЗХ-ны Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс хянан баталгаажуулсан үнэлгээний тайланд 60 онооны үнэлгээ авсан бөгөөд компанийн засаглалын кодексийн хэрэгжилт 83%-тай байна.</p>				
№	Гарчиг	Авбал зохионоо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	7	58%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5	83%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5	83%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	88%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8	80%
Нэгдсэн дүн		72	60	83%
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i>			
	<p>- Монгол улсын Засгийн газраас Монголд зочлох жилийг зарласантай холбогдуулан аялал жүүчлалын бүтээгдхүүн болон зочид гийчдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Үүнтэй уялдаад Улаанбаатар хотод зочид буудлын үйл ажиллагаа эрхлэгчид олширч орчин үеийн техник технологи нэвтрүүлсэн шинэ шинэ зочид буудлууд ихээр баригдах болсон. Шинээр нээгдэж байгаа зочид буудлууд нь эвэнт холл , өндөр тоног төхөөрөмж бүхий гоёмсог заал, амт чанар бүхий хоол үйлчилгээ, чадварлаг ажиллах хүчинтэй байгаа нь зочид гийчдийн урсгалыг өөрсөдөө татаж үйлчлүүлэгчдийн тоог бууруулах эрсдэл үүсгээд байна.</p>			
7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>			
	<p>Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид</p> <ol style="list-style-type: none"> 1. Х.Баттулга – 22.2% 2. Billy Lim Sin Pau – 18.12% 3. Х.Баттуул – 18.09% 4. Х.Цэндбаяр – 16.74% 5. Б.Эрхэс – 8.42% 			
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>			
	- Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.			
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>			
	- Компанийн ТУЗ-ийн 2025 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 02 тоот тогтоолоор компанийн 2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 330 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.			
10.	<i>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</i>			
	<p>- 23 дэх жилдээ хэрэгжиж байгаа Япон улсын зүрхний мэс заслын эмч нарын “Зүрх хамгаалах” төсөлтэй 2024 онд дахин хамтран ажиллалаа. “Зүрх хамгаалах төсөл”-ийн хүрээнд Япон, Монголын эмч нарын баг зүрхний төрөлхийн гажигтай 800 гаруй хүүхдэд судсан дотуурх мэс засал эмчилгээг амжилттай хийж, 9000 орчим хүүхдэд зүрхний эмгэгийн оношилгоо, эмчилгээг амжилттай хийсэн байна.</p> <p>- 2024 оны 4 дүгээр сараас эхлэн Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах дүнд түвшний төсөлд хамрагдан байгууллагаас 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд хоол үйлдвэрлэлээс гарсан хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж 60кг орчим бордоог боловсруулж байгууллагынхаа ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд ашиглан ажиллав.</p> <p>- “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК тай Хуванцар сав, лаазны хаягдал нийлүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулан хаягдал хуванцар, лааз нийлүүлэн байгал дэлхийгээ хамгаалахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.</p> <p>- Хоол үйлдвэрлэлээс ялгарсан өөх тосыг хамж савангийн үйлдвэрт нийлүүлэх ажил 2025 онд хэрэгжихээр төлөвлөгдөөд байна.</p>			

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо: 2025 оны 3 сарын 31

Овог, нэр: Х.Цэндбаяр

Албан тушаал: "Баянгол зочид буудал" ХК-ийн
Гүйцэтгэх
захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)



Овог, нэр: Д.Алтантөгс

Албан тушаал: "Фискал аудит" ХХК аудитын компанийн
гүйцэтгэх захирал

Гарын үсэг:
(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025 оны 3 сарын 31

Овог, нэр: С.Алтантуяа

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:

A handwritten signature in blue ink, appearing to be "S. Altantuuya".



AUDITING, ADVISORY, ASSURANCE

“ФИСКАЛ АУДИТ” ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот-14250
Сүхбаатар дүүрэг 4-р хороо, Сөүлийн
гудамж 23 Түшиг төв 505 тоот
Утас/факс: (976)-70106099, 99117709
E-mail: audit@fiscal.mn, altantugs@fiscal.mn

2025.03.27 № СТА-25/25

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ”-ХК-ИЙН
УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”)–оос гаргасан журмын дагуу үнэн зөв, бодитой тайлагнасан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн талаархи компаний удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”)–оос гаргасан журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материалаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

бүртгэлийн зохих бодлогыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилсан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдалд байгаа эсэхийг тодорхойлсон.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компаний тухай хууль”-ийн 5-р зүйлд заасан хуулийн этгээд болох “БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ



ДАЛТАНТӨГС